

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДСАНД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Зорилго: Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт.

Хамрах хүрээ: Үнэлгээнд 13 яам, 21 аймаг

Хугацаа: 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар гүйцэтгэв.

Эх сурвалж: 13 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудас


Арга зүй: Хуулиар хүлээсэн үүрэг буюу мэдээлбэл зохих мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэхийг үнэлэхдээ тухайн байгууллагын онцлог, чиг үүргээс хамаарч яамдад 41, аймагт 38 шалгуур үзүүлэлт боловсруулан хэрхэн хангасан эсэхийг хянан шинжлэв. Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхийг харгалзан 0-3 оноо, нийт 0-100 оноо өгөх замаар үнэлгээ хийв.

Үр дүн: Үнэлгээнд хамрагдсан 34 байгууллагын 21 нь буюу 61,7 хувь нь 60-аас доош оноотой үнэлэгдсэн нь Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлж байгааг илтгэж байна.



Яамдын цахим хуудсанд дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон

шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, хүний нөөцийн сул орон тооны зар, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулаагүй байв.



Аймгуудын цахим хуудсан дахь мэдээлэлтэй танилцахад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг хүлээн авах болон иргэд аж ахуйн нэгжээс өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, эрх бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл, журмын хамт байршуулаагүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлээгүй зэрэг зөрчил, дутагдал түгээмэл байна.

Цаашид Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол үнэлж, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах юм.

Авлигатай тэмцэх газар